



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/122

Мандалговь

Зохион байгуулалтын арга
хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Коронавируст (COVID-19) халдвараас урьдчилан сэргийлэх, идэвхтэй хөдөлгөөнийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл мэнд, дархлааг дэмжих зорилгоор спиннинг, фитнесийн чиглэлээр ажилладаг байгууллага, аж ахуй нэгжийг 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс хэвийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Үйл ажиллагаа явуулахдаа коронавируст (COVID-19) халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг мөрдөж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол зохион байгуулж ажиллахыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуй нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (О.Амарсанаа) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА, АЙМГИЙН ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010354